



ИНД-115

ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАГЦ ДҮРЭМ

**СОНИРХОГЧИЙН НИСЛЭГИЙН ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ БА
ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Иргэний нисэхийн ерөнхий газар

Дүрмийн тайлбар

Энэ дүрэм нь сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааг явуулж байгаа этгээдийг гэрчилгээжүүлэх, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлно.

ИНД 115-ийн зорилго нь сонирхогчийн нислэгийг **салбарыг** зохицуулах шинэ дүрэм боловсруулан гаргахад оршино. ИНД-115-ээр сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааны операторуудыг ИНД-119 болон ИНД-135-ийн дагуу нисдэг тэрэг болон жижиг оврын агаарын хөлөг ашигладаг агаарын тээврийн операторуудыг гэрчилгээжүүлэхтэй ижил төстэй арга замаар гэрчилгээжүүлэхийг шаардаж байгаа юм. Тухайлбал, операторууд нь тэдгээрийн үйл ажиллагааны үзүүлэнг үзүүлэх замаар Даргад дараах зүйлийг нотолсон байх шаардлагатай **ндаа дараах зүйлсийг бий болгосон гэдгээ Даргад нотлон харуулах шаардлагатай.**

- аюулгүй **ажиллагааны** холбогдох стандартуудыг даган мөрдөх үүднээс зүй зохистой удирдлагын систем, бүтэц, үйл ажиллагааны зааврыг хэрэгжүүлсэн байх;
- зохих хэмжээнд сургагдаж, ур чадвар эзэмшсэн ажилтнуудтай байх;
- үйл ажиллагааны даалгаврыг биелүүлэхэд тохиромжтой, техник үйлчилгээ зохистой түвшинд хийгдсэн агаарын хөлөгтэй байх, үндсэн ажилтнууд нь тэдгээрийн үүргийг хэрэгжүүлэхэд зөв бөгөөд тохирох хүмүүс байх.

Энэхүү дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Сайдын баталсан ИНД-115-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-115, дүрмийн өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг дүрмийн зохицуулалтад шилжих тухай Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/ -ын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг Шинэ Зеландын Иргэний нисэхийн дүрэмд уялдуулан гаргасан болно.

ИНД-115 нь анх 2003 оны 07 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд дараах өөрчлөлтийг багтаасан:

Өөрчлөлтийн дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо
Өөрчлөлт 1	2010 оны 5 сарын 7
Өөрчлөлт 2	20 оны...сарын...

ИНД-115-ын 2 дахь Өөрчлөлтийг Шинэ Зеландын Part 115, 2016 оны 2-р сарын 01-ний өдрийн Өөрчлөлт 3-д үндэслэн боловсруулсан болно.

Тэмдэглэл: ИНД-115-г англи болон монгол хэл дээр боловсруулсан ба эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хувилбар нь давамгайлна.

Гарчиг

А Бүлэг.	Ерөнхий зүйл	9
115.1	Зорилго.....	9
115.3	Тодорхойлолт	9
115.5	Гэрчилгээний шаардлага	9
115.7	Өргөдөл гаргах.....	9
115.9	Гэрчилгээ олгох	10
115.11	Гэрчилгээ эзэмшигчийн эрх.....	10
115.13	Үйл ажиллагааны тодорхойлолт	11
115.15	Дээд хугацаа.....	12
115.17	Үйл ажиллагааг зогсоох мэдэгдэл.....	12
115.19	Гэрчилгээ дахин олгох	12
115.21	Шилжилтийн үеийн зохицуулалт	12
Б Бүлэг.	Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшихэд тавигдах шаардлага	13
115.51	Удирдах ажилтны мэргэшил, туршлага	13
115.53	Ажилтнуудын ур чадварт тавигдах шаардлага	14
115.55	Хангалтанд тавигдах шаардлага	14
115.57	Үзүүлэх нислэг буюу тест.....	15
115.59	Техник үйлчилгээний журам.....	15
115.61	Техник үйлчилгээний хөтөлбөр	15
115.62	Мансууруулах бодис болон согтууруулах ундааны хөтөлбөр.....	17
115.63	Бичиг баримт	17
115.65	Ажилтнуудын бүртгэл	17
115.67	Нөөцийн бүртгэл.....	18
115.69	Нислэгийн зөвшөөрөл болон хяналт	18
115.71	Нислэг дагах үйлчилгээ	19
115.73	Ашиглалтын журмыг тогтоох.....	20

115.75	Осол зөрчлийг мэдээлэх.....	20
115.77	Аюулгүй ажиллагааны удирдлага	20
115.79	Сонирхогчийн нислэгийн операторын үйл ажиллагааны заавар.....	20
В Бүлэг.	Үйл ажиллагааны хязгаарлалт болон шаардлага.....	22
115.101	Байнгын хэрэгжилт	22
115.103	Нисгэх багийн мэргэшил	23
115.105	Бизнесийн буюу худалдааны нэр.....	23
115.107	Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигчийн хязгаарлалт	24
115.109	Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагад өөрчлөлт оруулах.....	24
115.111	Техник үйлчилгээний хөтөлбөрт өөрчлөлт оруулах	25
115.151	Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигчид болон өргөдөл гаргагчийн шилжилт.....	25
115.153	Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигчид болон өргөдөл гаргагчийн байгууллагын шилжилтийн удирдлагын систем	27
Г Бүлэг.	Нислэгийн үйл ажиллагаа.....	28
115.201	Үйл ажиллагааг хязгаарлах буюу цуцлах	28
115.203	Зорчигчийн аюулгүй байдал.....	29
115.205	Зорчигчийн сургалт болон брифинг	29
115.207	Онцгой байдлын тоног төхөөрөмжийн шаардлага.....	29
115.209	Онцгой байдлын нөхцөлд авах арга хэмжээний төлөвлөгөө	30
115.211	Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналтын жагсаалт	31
115.213	Нислэгийн бэлтгэл болон нислэгийн төлөвлөлт	31
115.215	Удирдлагыг залах.....	31
115.217	Усан дээгүүрх нислэг	32
115.219	Аэродром, буултын бүс болон хөөргөх талбайг ашиглах.....	32
115.221	Цаг уурын нөхцөл.....	33
115.223	Агаарын хөлгийн ачаалалтын хязгаарлалт	33
115.225	Нислэгт тэнцэх чадварын үүрэг хариуцлага.....	34
115.227	Шатахуун.....	34
115.229	Аюултай ачаа тээвэрлэх.....	35

115.231	Нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөх ажилтан хөдөлмөрийн чадвараа алдах.....	35
Д Бүлэг .	Сургалт	36
115.301	Сургалт – Ерөнхий зүйл.....	36
115.303	Нисгэх баг болон газрын багийн сургалтын хөтөлбөр.....	36
115.305	Нисгэх багийн гишүүд болон газрын багийн анхан шатны сургалт	37
115.307	Нисгэх багийн гишүүд болон газрын багийн шилжилтийн сургалт	38
115.309	Нисгэх багийн гишүүд болон газрын багийн давтан сургалт.....	38
115.311	Нисгэх багийн багш гишүүний мэргэшил.....	38
115.313	Сургалтын бүртгэл	39
Е Бүлэг.	Багийн гишүүн болон газрын багийн ур чадварын шаардлага.....	39
115.351	Нислэгийн ур чадварыг үнэлэх хөтөлбөр	39
115.353	Нисгэх багийн ур чадварын шалгалт	39
115.355	Багийн гишүүн болон газрын багийн гишүүн ур чадварын хяналтын жагсаалт	41
115.357	Шалгагч нисгэгчийн ур чадвар	42
115.359	Багийн гишүүний тест буюу нислэгийн шалгалтыг шаардлагатай өдрөөс өмнө дуусгах.....	43
115.361	Ур чадвар болон нислэгийн шалгалтыг шаардлагатай өдрөөс өмнө дуусгах.....	43
Ж Бүлэг.	Нисгэх багийн ядаргаа.....	43
115.401	Операторын үүрэг хариуцлага – нислэг болон ажлын схем	43
115.403	Нисгэх багийн гишүүний үүрэг хариуцлага – нислэгийн болон үүргийн цаг.....	44
З Бүлэг.	Гарын авлага, протокол болон бүртгэл	44
115.451	Ажиллагааны мэдээлэл	44
115.453	Авч явах бичиг баримтууд	45
115.455	Өдөр тутмын нислэгийн бүртгэл	45
115.457	Хадгалах хугацаа	46
И Бүлэг.	Халуун агаарын бөмбөлгийн ажиллагаа	47
115.501	Нислэгт тэнцэх чадвар – халуун агаарын бөмбөлөг.....	47
115.503	Хэрэгсэл болон тоног төхөөрөмж – халуун агаарын бөмбөлөг.....	47

115.505	Техник үйлчилгээ – халуун агаарын бөмбөлөг.....	47
115.507	Нисгэгчийн мэргэшил болон туршлагын шаардлага – халуун агаарын бөмбөлөг.....	47
К Бүлэг.	Шүхэр буулгах агаарын хөлгийн ажиллагаа.....	48
115.551	Нислэгт тэнцэх чадвар – шүхэр буулгах агаарын хөлөг.....	48
115.553	Хэрэгсэл болон тоног төхөөрөмж – шүхэр буулгах агаарын хөлөг.....	48
115.555	Техник үйлчилгээ – шүхэр буулгах агаарын хөлөг.....	48
115.557	Ажиллагааны журам – шүхэр буулгах агаарын хөлөг.....	49
115.559	Нисгэгчийн мэргэшил болон туршлагын шаардлага – шүхэр буулгах агаарын хөлөг.....	49
Л Бүлэг.	Тандем шүхрийн ажиллагаа.....	49
115.571	Нислэгт тэнцэх чадвар болон тоног төхөөрөмж – тандем шүхэр.....	49
115.573	Техник үйлчилгээ – тандем шүхэр.....	50
115.575	Ажиллагааны журам – тандем шүхэр.....	50
115.577	Тандем шүхрийн мастерын мэргэшлийн шаардлага.....	50
М Бүлэг.	Планерын ажиллагаа.....	51
115.601	Нислэгт тэнцэх чадвар – планер.....	51
115.603	Хэрэглэл болон тоноглол – планер.....	51
115.605	Техник үйлчилгээ – планер.....	51
115.607	Нисгэгчийн мэргэшил болон туршлагын шаардлага - планер.....	52
115.609	Планерыг нислэгт чирэх.....	52
115.611	Ажиллагааны хязгаарлалт - планер.....	53
115.613	Залуурыг удирдах – планер.....	53
Н Бүлэг.	Дельтаплан болон параглайдерын ажиллагаа.....	54
115.651	Нислэгт тэнцэх чадвар – дельтаплан болон параглайдер.....	54
115.653	Хэрэгсэл болон тоног төхөөрөмж – Дельтаплан болон параглайдер.....	55
115.655	Техник үйлчилгээ – дельтаплан болон параглайдер.....	55
115.657	Агаарын хөлгийн таних тэмдэг – дельтаплан болон параглайдер.....	56
115.659	Нисгэгчийн мэргэшлийн шаардлага – дельтаплан болон параглайдер.....	56
115.661	Ажиллагааны шаардлага – Дельтаплан болон параглайдер.....	56

115.663	Зорчигчийн аюулгүй байдлын шаардлага – дельтаплан болон параглайдер.....	57
115.667	Залуурыг удирдах – Дельтаплан болон параглайдер	58
О Бүлэг .	Нөөц	59
П Бүлэг .	Тусгай агаарын хөлгийн ажиллагаа.....	59
115.751	Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар	59
115.753	Хэрэгсэл болон тоног төхөөрөмж.....	59
115.755	Агаарын хөлгийн техник үйлчилгээ	59
115.757	Нисгэгчийн мэргэшил болон туршлагын шаардлага	60
115.759	Залуурыг удирдах – зохиомол цэргийн ажиллагаа.....	61
Р Бүлэг .	Хэт хөнгөн агаарын хөлгийн ажиллагаа	62
115.801	Нислэгт тэнцэх чадвар – хэт хөнгөн агаарын хөлөг.....	62
115.803	Хэрэгсэл болон тоног төхөөрөмж – хэт хөнгөн агаарын хөлөг	62
115.805	Техник үйлчилгээ – хэт хөнгөн агаарын хөлөг	62
115.807	Техник үйлчилгээний бүртгэл	63
115.809	Нисгэгчийн мэргэшил болон туршлагын шаардлага – хэт хөнгөн агаарын хөлөг.....	63
115.811	Хамгийн бага өндөр – хэт хөнгөн агаарын хөлөг	63
Appendix A.	Удирдах хүмүүсийн мэргэшил болон чадвар	Error! Bookmark not defined.

А Бүлэг. Ерөнхий зүйл

115.1 Зорилго

Энэ дүрэм нь сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаа явуулах этгээдийг гэрчилгээжүүлэх болон **тэдгээрийн** үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлно.

115.3 Тодорхойлолт

Энэ дүрмэнд —

Сонирхогчийн уран жолоодлогын нислэгийн ажиллагаа гэж уран **жолоодлогын** нислэгийг багтаасан сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааг:

~~Сонирхогчийн формацийн нислэгийн ажиллагаа~~ гэж ~~формацийн нислэгийг багтаасан сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааг~~ **Жагсаалаар нисэх ажиллагаа** гэж **хоёр, эсхүл түүнээс дээш тооны агаарын хөлөг дэг журамтай нэгэн зэрэг нислэг үйлдэх ажиллагааг:**

Газрын багийн гишүүн гэж сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигчээс газар дах ажил үүргийг хариуцуулсан, операторын зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтанд хамрагдсан, сонирхогчийн нислэгийн аюулгүй ажиллагааг зайлшгүй шаардлагатай этгээдийг:

Цэргийн дуураймал нислэгийн ажиллагаа гэж зохиомол агаарын тулаан, эсхүл араас хөөх зэрэг хөдөлгөөнийг хийж байгаа нэг, эсхүл түүнээс олон агаарын хөлөг оролцсон эсхүл нэг, эсхүл түүнээс олон агаарын хөлөг цэргийн нислэг хийж байгаа сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааг.

115.5 Гэрчилгээний шаардлага

Хууль болон Энэ дүрмийн дагуу Даргаас олгосон сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээний эрхийн дагуу, ~~болон олгосон эрхийн дагуу ажиллахаас бусад тохиолдолд~~ **эрх, зөвшөөрлөөс өөрөөр** аливаа этгээд сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

115.7 Өргөдөл гаргах

Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь САА 24115/01 маягыг бөглөж, Даргад өргөн барихдаа дараах материалыг хавсаргана—

- (1) 115.79-д шаардсан өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны **заавар**;
- (2) 115.13(b)-д заасан үйл ажиллагааны дэлгэрэнгүй тодорхойлолт.

115.9 Гэрчилгээ олгох

Дарга дараах тохиолдолд **жууль болон** энэ дүрмийн дагуу сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээг олгоно—

- (1) өргөдөл гаргагч нь Б Бүлгийн холбогдох шаардлагыг биелүүлсэн байх;
- (2) 115.51(а)(1) болон (2)-д шаардсаны дагуу өргөдөл гаргагч болон түүний удирдах ажилтнууд нь зөв бөгөөд тохирсон хүмүүс байх;
- (3) гэрчилгээг олгосноор нислэгийн **нисэхийн** аюулгүй ажиллагааны ашиг сонирхолд харшлахгүй байх.

115.11 Гэрчилгээ эзэмшигчийн эрх

(а) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ болон дагалдах үйл ажиллагааны тодорхойлолтонд гэрчилгээ эзэмшигчээр гүйцэтгүүлэхээр зөвшөөрсөн, сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааны төрлийг тухайлан заана.

(b) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ болон дагалдах үйл ажиллагааны тодорхойлолт нь гэрчилгээ эзэмшигчид дараах эрхийг олгож болно—

- (1) сонирхогчийн нислэгийн дараах үйл ажиллагааг явуулах:
 - (i) *стандарт ангиллын* нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ бүхий агаарын хөлөг буюу нисдэг тэрэгний А цэгээс А цэг рүү нислэгийн явцад **формагийн нислэг жагсаалаар нисэх ажиллагаа**, уран **жолоодлогын** нислэгийн маневр, болон огцом өндөр авах, огцом өндөр алдах, огцом эргэх гэх мэт ижил төрлийн стандарт бус нислэгийн маневр хийх;
 - (ii) *тусгай ангиллын-үндсэн, тусгай ангиллын-спортын хөнгөн агаарын хөлгийн, эсхүл тусгай ангиллын-хязгаарлагдмал* нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ бүхий агаарын хөлгөөр А цэгээс А цэг рүү (үүнд газар уснаа явагч агаарын хөлгийн усанд буух завсрын буулт багтана) нислэгийн явцад **формагийн нислэг жагсаалаар нисэх ажиллагаа**, уран **жолоодлогын** нислэгийн маневр болон огцом өндөр авах, огцом өндөр алдах, огцом эргэх гэх мэт ижил төрлийн стандарт бус нислэгийн маневр хийх;
 - (iii) 2 дугаар ангиллын хэт хөнгөн агаарын хөлгийн А цэгээс А цэг рүү нислэг;
 - (iv) халуун агаарын бөмбөлгийн нислэг;
 - (v) планерын нислэг;
 - (vi) шүхэр буулгах агаарын хөлгийн нислэг;

- (vii) тандем шүхрийн нислэг;
- (viii) тандем дельтаплан буюу параглайдерын нислэг;
- (2) 115.301-р журамлан шаардсан сургалтын хөтөлбөрийн дагуу газрын буюу нислэгийн сургалт явуулах;
- (3) 115.351-р журамлан шаардсан ажиллагааны чадварыг үнэлэх хөтөлбөрийн дагуу тест, шалгалтын нислэг үйлдэх;
- (4) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааварт жагсаасан үйлчилгээ үзүүлэх, ажиллагаа явуулах бусад хүмүүсийн чадварыг тогтоох тест, шалгалт явуулах.

115.13 Үйл ажиллагааны тодорхойлолт

(a) Хууль болон энэ дүрмийн дагуу Даргын олгосон сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээнд (b) хэсэгт заасан шаардлагыг хангасан, үйл ажиллагааны тодорхойлолтыг хавсаргасан байна. **хавсаргана.**

(b) Үйл ажиллагааны тодорхойлолтод дараах зүйлийг агуулсан байна **тусгана** —

- (1) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа явуулах үндсэн баазын байрлалын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (2) халуун агаарын бөмбөлөг, дельтаплан болон параглайдерын ажиллагаанаас бусад тохиолдолд гэрчилгээ эзэмшигч энэ хэсгийн (5)-д заасан сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаа явуулах зорилгоор ашиглах зөвшөөрөл авсан байрлал бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (3) гэрчилгээ эзэмшигчийн Монгол Улсад үйлчилгээ үзүүлэх хаяг;
- (4) гэрчилгээ эзэмшигч үйл ажиллагаа явуулж болох бизнесийн нэрсийн жагсаалт;
- (5) гэрчилгээ эзэмшигчийн явуулах зөвшөөрөл авсан сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааны төрлүүдийн жагсаалт;
- (6) энэ хэсгийн (5)-д заасан ~~гэрчилгээ эзэмшигчийн сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаанд~~ **нислэгийн үйл ажиллагааны төрөлд** ашиглах зөвшөөрөл бүхий агаарын хөлөг бүрийн маяг, серийн дугаар, таних тэмдэг болон бүртгэлийн жагсаалт;
- (7) халуун агаарын бөмбөлөг, дельтаплан болон параглайдерын ажиллагаанаас бусад тохиолдолд гэрчилгээ эзэмшигчийн энэ хэсгийн (5)-д заасан сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаанд ашиглах зөвшөөрөл бүхий маршрут болон талбайн жагсаалт, үүнд нисэн гарах цэгээс үйлчлэх аливаа хязгаарлалт буюу нислэгийн дээд алслалт багтана;

- (8) энэ дүрэм буюу холбогдох бусад дүрэмд заасан шаардлагаас гэрчилгээ эзэмшигчийг чөлөөлсөн чөлөөлөлтийн жагсаалт:
- (9) энэ хэсгийн (5)-д заасан сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаанд хамаарах аюулгүй ажиллагааны аливаа хязгаарлалт буюу шаардлагын дэлгэрэнгүй мэдээлэл:
- (10) Дарга тодорхой нөхцлийг хангахад шаардлагатай гэж тогтоосон бусад нөхцлийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл.

115.15 Дээд хугацаа

Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээг дээд тал нь 5 жилийн хугацаатай олгох, эсхүл сунгаж болно.

115.17 Үйл ажиллагааг зогсоох мэдэгдэл

Сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаагаа зогсоож байгаа сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь энэ тухай зогсоосон өдрөөс хойш 30 хоногийн дотор Даргад мэдэгдэх үүрэгтэй.

115.19 Гэрчилгээ дахин-өлгөх сунгах

Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь 115.7-ийн дагуу САА 24115/01 маягтаар сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээний хүчин төгөлдөр хугацааг дахин авахаар сунгуулахаар өргөдөл гаргана. (АС115-1 –ийг нь үзлээ. Сунгалтын асуудал байна.)

115.21 Шилжилтийн үеийн зохицуулалт

(a) 115.5 болон тусгай ангиллын нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ бүхий агаарын хөлгийг ашиглах ажиллагаанаас бусад тохиолдолд 2016 оны 2 сарын 1-ний өдрөөс өмнө планераар сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаа явуулж байгаа этгээд нь 2018 оны 2 сарын 1-ний өдрийг хүртэл энэ дүрмийн шаардлагаас чөлөөлөгдөнө.

(b) 115.101(b)(3)(ii)-ыг үл хамааран, 2012 оны 12 сарын 15-ны өдрөөр хүчин төгөлдөр байгаа сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагааны зааварт заасан байрлал бүрт 115.79(a)(8)-аар шаардсан дэлгэрэнгүй мэдээллийг бэлэн болгосон бол 2013 оны 3 сарын 15 хүртэл 115.79(a)(8)-ын дагуу шаардсан дэлгэрэнгүй мэдээллийг үйл ажиллагааны зааварт тусган өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

Б Бүлэг. Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшихэд тавигдах шаардлага

115.51 Удирдах ажилтны мэргэшил, туршлага

(а) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь дараах хүмүүсийг ажилд авах, гэрээгээр ажиллуулах, эсхүл өөр байдлаар ажиллуулах ёстой —

(1) ерөнхий захирал гэж томилогдсон удирдах ажилтан нь —

- (i) гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын үйл ажиллагааг энэ дүрэмд заасан шаардлага, стандартын дагуу явуулж, санхүүжүүлэхийг хариуцах эрх мэдэлтэй байна;
- (ii) гэрчилгээ эзэмшигчийн байгууллага нь энэ дүрэмд заасан шаардлага, стандартыг биелүүлэхийг хариуцах үүрэгтэй байна;

(2) удирдах албан тушаалтан буюу албан тушаалтнууд нь—

- (i) өргөдөл гаргагчийн байгууллага нь үйл ажиллагааны заавраа даган биелүүлэхийг хариуцах үүрэгтэй;
- (ii) энэ зүйлийн (b)(1)-д заасан үйл ажиллагааг хариуцна;
- (iii) ерөнхий захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээнэ.

(3) өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт жагсаасан ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах, гэрчлэх хангалттай тооны ажилтан.

(b) Энэ зүйлийн (а)-аар шаардсан удирдах албан тушаалтан, эсхүл албан тушаалтнууд нь—

(1) өргөдөл гаргагчийн байгууллагын хэмжээ, төсөөлөгдөж буй цар хүрээний үр дагавраар Дарга өөрөөр хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд хүн бүр дараах чиг үүргүүдээс нэгээс илүүгүйг хариуцна—

- (i) нислэг болон буух ажиллагаа, аливаа хамаарах газрын үйлчилгээг хамаарсан сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаа;
- (ii) нисгэх багийн гишүүн болон газрын багийн сургалт, чадварын үнэлгээ;
- (iii) техник үйлчилгээний хяналт болон цагийн хуваарь;
- (iv) 115.77-д заасны дагуу шаардагдах аюулгүй ажиллагааны удирдлагын систем;
- (v) ИНД-12-д заасны дагуу зөрчлийн шалгалт явуулах;

(2) тухайн хүний хариуцаж байгаа чиг үүрэгт хамаарах Хавсралт А-д үзүүлсэн мэргэшил, ур чадвар, болон туршлагын доод шалгуурыг хангасан байх.

115.53 Ажилтнуудын ур чадварт тавигдах шаардлага

(a) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь өөрийн үйл ажиллагааны зааварт жагсаасан сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, удирдлага, хяналт болон баталгааны журмуудыг тогтоох ёстой, үүнд —

- (1) өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт жагсаасан сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, удирдах, шалгах буюу батлахаар өргөдөл гаргагчаас эрх олгосон ажилтнуудын эхний үнэлгээ болон ур чадварыг хадгалах;
- (2) энэ хэсгийн (1)-д заасан албан тушаалтанд эрхийн хамрах хүрээг оруулсан **тушаалтны эрх мэдлийг заасан** зөвшөөрөл бичгээр олгох.

(b) Өргөдөл гаргагч нь ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн Нисэхийн сургалтын байгууллага, эсхүл энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу өөрийн ажилтнуудын ур чадварыг үнэлэхээр шалгах буюу **ур** чадварыг хадгалах сургалт явуулах зөригчээр зөхиж гэрчилгээгээр олгогдсон зөвшөөрөл бүхий ИНД-149-ийн дагуу гэрчилгээжсэн Сонирхогчийн нислэгийн клубтэй гэрээ хийж болно.

(c) Энэ зүйлийн (b)-ийн дагуу байгууллагатай гэрээ хийсэн өргөдөл гаргагч нь өөрийн үйл ажиллагааны зааварт дараах дэлгэрэнгүй мэдээллийг тусгана **өрүүлнэ**—

- (1) тухайн байгууллагатай гэрээ байгуулах чиг үүрэгүүд **гэрээгээр хийгдэх ажил үйлчилгээнүүд**;
- (2) тухайн байгууллагын явуулах шалгалт буюу сургалтын **хамрах цар** хүрээ;
- (3) явуулах шалгалт, сургалтын чиг үүрэгтэй холбоотой тухайн байгууллагад олгосон эрх, **мэдээ зөвшөөрөл**.

115.55 Хангалтанд тавигдах шаардлага

(a) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь өөрийн үйл ажиллагааны зааварт жагсаасан сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааг явуулах нөөцийг хангалттай бүрдүүлж Даргаар хүлээн зөвшөөрүүлэх үүрэг хүлээнэ. **Үүнд :**

- (1) ~~Үүнд түүнчлэн дараах хангалтыг оруулна—~~
 - (i) 1. өрөн сууц, **байр**, оффис, цех, ангар болон барилгууд **байгууламж**;
 - (ii) 2. өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт жагсаасан ажиллагааг явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал, сургалтын төхөөрөмж, өгөгдөл мэдээлэл болон баримт бичиг.

(b) Өргөдөл гаргагч нь дараах орчныг бүрдүүлэх үүрэг хүлээнэ—

- (1) гүйцэтгэх даалгаврыг биелүүлэхэд тохирсон байх;
- (2) зөхийх—тохиолдолд **шаардлагатай гэж үзвэл**, цаг агаарын нөхцлөөс хамгаалсан байх.

115.57 Үзүүлэх нислэг буюу тест

(a) Хэрэв Дарга шаардвал Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь энэ дүрэм буюу бусад холбогдох дүрэмд заасан **хамаарах** шаардлагуудыг хангаж чадна гэдгээ Даргад нотлон харуулахын тулд үзүүлэх нислэг буюу тестийг гүйцэтгэж болно.

(b) Нислэг буюу тестийг Дарга хүлээн зөвшөөрөх арга замаар гүйцэтгэнэ.

115.59 Техник үйлчилгээний журам

(a) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь дараах агаарын хөлөг болон төхөөрөмжийн нислэг тэнцэх чадварыг **байнга ТОГТМОЛ** хадгалах журмыг тогтооно—

- (1) гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу ашиглаж агаарын хөлөг бүрийн;
- (2) агаарын хөлөгт суурилуулсан буюу хавсаргасан аливаа тоног төхөөрөмжийн

(b) ~~Өөрийн агаарын хөлөг буюу тоног төхөөрөмжийн техник үйлчилгээг өөр хүнээр гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн,~~ сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь 115.79-ийн шаардлагын дагуу **өөрийн агаарын хөлөг буюу тоног төхөөрөмжийн техник үйлчилгээг өөр хүнээр гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн бол өөрийн үйл ажиллагааны заавартаа** дараах **дэлгэрэнгүй мэдээллийг дэлгэрэнгүй** оруулна—

- (1) өөр этгээдэд шилжүүлсэн чиг үүргүүд **ажил үйлчилгээнүүд**;
- (2) өөр этгээдээр гүйцэтгүүлэх техник үйлчилгээний ~~хамрах~~ **цар** хүрээ;
- (3) гүйцэтгэх чиг үүрэг болон техник үйлчилгээтэй холбоотой тухайн өөр этгээдэд олгосон эрх ~~мэдэл~~ **зөвшөөрөл**.

115.61 Техник үйлчилгээний хөтөлбөр

(a) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь гэрчилгээгээр олгогдсон зөвшөөрлийн дагуу ашиглах агаарын хөлөг, шүхрийн иж бүрдэлд зориулан техник үйлчилгээний ~~хөтөлбөрийг төгтөөнө~~ **хөтөлбөртэй байна**.

(b) Энэ зүйлийн (a)-аар шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрт дараах зүйлийг тусгах үүрэгтэй—

- (1) хөтөлбөрт хамрагдах агаарын хөлөг бүрийн маяг, серийн дугаар, таних тэмдэг болон бүртгэлийн тэмдэг;
- (2) агаарын хөлөг болон түүний бүрэлдэхүүн хэсэгт шаардагдах үзлэг, шалгалтыг хамруулан компонент агаарын хөлгийн техник үйлчилгээг гүйцэтгэх журам, заавар. Түүнчлэн дараах ~~сэлбэг, материалыг~~ **зүйлийг** нарийвчлан тусгана:
 - (i) зайлшгүй үзлэг хийх шаардлагатай **талаар**;
 - (ii) засвар үйлчилгээг зөв гүйцэтгээгүй, эсхүл буруу сэлбэг, материал ашигласан тохиолдолд агаарын хөлгийн аюулгүй ашиглалтанд сөргөөр нөлөөлөх гэмтэл, доголдол эсхүл эвдрэлд хүргэх **талаар**.
- (3) энэ хэсгийн (2)-ын дагуу техник үйлчилгээ хийх хугацаа, мөчлөг, календарийн цаг, системийн ажиллагааны тоо буюу эдгээрийн аливаа хослолоор илэрхийлсэн үйлчилгээг гүйцэтгэх хуваарь;
- (4) агаарын хөлгийг техник үйлчилгээний хөтөлбөрт ~~өруулах~~ **хамруулах** журам;
- (5) хөтөлбөрөөр шаардаж байгаа үзлэг бүрийг гүйцэтгэж байгааг баталгаажуулах журам;
- (6) **мэдээллэх жишээ/загварыг тусгасан**, дутагдлыг ~~бүртгэж~~ **мэдээллэх** журам, ~~үүнд бүртгэлийн жишээ багтана~~;
- (7) техник үйлчилгээний үеэр илэрсэн дутагдлыг засах буюу хойшлуулах журам;
- (8) дараах материалыг хадгалах журам, үүнд—
 - (i) 91.623-ийн дагуу хийх техник үйлчилгээний бүртгэлүүд;
 - (ii) шүхрийн иж бүрдэл, дельтаплан, эсхүл пара**глайдер**ын хувьд—
 - (A) гүйцэтгэсэн ажлын тодорхойлолт буюу Дарга хүлээн зөвшөөрөхүйц өгөгдлийн лавлагаа;
 - (B) хэрэв тухайн ажлыг өргөдөл гаргагчийн техник үйлчилгээний байгууллагаас өөр этгээд гүйцэтгэх бол тухайн үйлчилгээнд оруулахыг зөвшөөрсөн этгээдийн нэр.

(c) Энэ зүйлийн (b)(2)-т шаардсан журам заавар нь дараах дүрмийн зохицуулалттай ижил байх шаардлагатай—

- (1) ИНД-91-ийн Ж Бүлэгт заасан холбогдох шаардлага;
- (2) энэ дүрмэнд заасан холбогдох шаардлага;

- (3) үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарь.

115.62 Мансууруулах бодис болон согтууруулах ундааны хөтөлбөр

Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь дараах ажилтнуудыг аливаа мансууруулах бодис, согтууруулах ундаа хэрэглэхтэй холбоотой эрсдлийг ажиглаж, **хянаж**, удирдах “мансууруулах бодис болон согтууруулах ундааны хөтөлбөр”-ийг ~~тогтооно~~ **тэй байна**. —

- (1) нисгэх багийн гишүүн;
- (2) тандем шүхрийн мастер;
- (3) газрын багийн гишүүн;
- (4) хийж байгаа ажил нь сонирхогчийн нислэгийн аюулгүй ажиллагаанд шууд нөлөөлөх бусад этгээд.

115.63 Бичиг баримт

(a) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь ИНД-91 болон 115-ыг оруулаад, гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүй, хамаарах аливаа дүрмээр шаардагдах бичиг баримтуудыг хянах, өөрчлөх, тараах журмыг тогтооно.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан журманд дараах зүйлийг шаардана—

- (1) бүх баримт бичгийг гаргахын өмнө эрх бүхий удирдах ажилтан шалгаж, зөвшөөрөл олгоно;
- (2) холбогдох бүх баримт бичгийн хүчин төгөлдөр хувийг цаасан, электрон буюу Даргын зөвшөөрөх бусад хэлбэрээр байрлал бүрт ажилтнууд шаардлагатай үед үзэж болохоор бэлэн байлгана;
- (3) ~~жуучирсан~~ **хэрэглээнээс гарсан** баримт бичгийг ~~гаргасан буюу хэрэглэсэн~~ **бүх цэгээс тухай бүр эргэлтээс гаргана** **нэн даруй ашиглалтаас хасна**;
- (4) баримт бичигт оруулах өөрчлөлтийг эрх бүхий удирдах ажилтан шалгаж, зөвшөөрөл олгоно;
- (5) баримт бичгийн хувь бүрийн хамгийн сүүлийн хувилбарыг тэмдэглэж хүчингүй болсон материалыг ~~ашиглахаас сэргийлсэн байна~~ **ашиглахгүй байх**.

115.65 Ажилтнуудын бүртгэл

Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь дараах зүйлийг ~~баталсан~~ **бататгасан** журмуудыг тогтооно—

- (1) дараах зүйлийн **зүйлсийн талаар** үнэн зөв бүртгэлийг хөтөлнө—
- (i) ажил үүрэг гүйцэтгэхийн тулд үнэмлэх, зэрэглэл буюу гэрчилгээ эзэмших шаардлагатай ажилтан бүрийн;
 - (ii) захирлын ажил үүрэг эсхүл бүрэн эрхийг шилжүүлэн хэрэгжүүлж байгаа ажилтан бүрийн;
 - (iii) гэрчилгээ эзэмшигчээс олгосон аливаа эрхийг хэрэгжүүлж байгаа ажилтан бүрийн.
- (2) **дээрх** бүртгэлд дараах дэлгэрэнгүй мэдээллийг тусгасан байна—
- (i) энэ хэсгийн (1)-д заасан ажилтан бүрийн холбогдох туршлага, мэргэшил болон сургалт;
 - (ii) энэ хэсгийн (1)(i)-д заасан аливаа үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээний хүрээ, хүчинтэй байдал болон хүчинтэй хугацаа;
 - (iii) энэ хэсгийн (1)(ii)-д заасан эрх үүргийн хуваарилалт;
 - (iv) энэ хэсгийн (1)(iii)-д заасан эрхийн зөвшөөрөл;
- (3) бүртгэлийг дор заасан үйл явдлаас хойш 6 жил хадгална, үүнд тухайн ажилтан—
- (i) үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээ шаардах ажил үүрэг гүйцэтгэхийг зогсоосноос хойш;
 - (ii) аливаа эрх үүрэг буюу шилжүүлэн авсан эрхийг хэрэгжүүлэхийг зогсоосноос хойш.

115.67 Нөөцийн бүртгэл

Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь гэрчилгээнд заасан үйл ажиллагааг явуулахад ашиглахаар **нөөцийг нөөцөлсөн эд зүйлсийг** турших, шалгах, тохируулах ажлын дэлгэрэнгүй мэдээллийг үнэн зөвөөр бүртгэх журам тогтооно.

115.69 Нислэгийн зөвшөөрөл болон хяналт

Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь гэрчилгээ эзэмшигчийн эрхэлж байгаа ~~сонирхогчийн нислэгт~~ **үйл ажиллагаа нь 115.51(b)(1)(i)-д заасан этгээдээр зөвшөөрөл олгож зөвшөөрөгдсөн эсэхийг бататгах** журам тогтооно.

115.71 ~~Нислэг дагах үйлчилгээ~~ Нислэгийн хяналт

(a) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу явуулж байгаа сонирхогчийн нислэг ~~бүрт нислэг дагах үйлчилгээ үзүүлэхийг баталгаажуулах~~ **бүрийг хянах** журам тогтооно.

(b) Энэ зүйлийн (a)-т шаардсан журмаар сонирхогчийн нислэгийн ~~үйл ажиллагаа бүрт нислэг дагах үйлчилгээ үзүүлж байгаа~~ **нислэгийг хянах** этгээд нь —

- (1) дараах мэдээлэлтэй байхыг шаардана:
 - (i) агаарын хөлгийн бүртгэл буюу таних тэмдэг;
 - (ii) агаарын хөлгийн маяг;
 - (iii) нисэн гарах аэродром буюу нисэн гарах бүс болон төлөвлөсөн буух бүсийн байрлал;
 - (iv) хэрэв шаардлагатай бол, шатахууны ~~хамгийн бага~~ зарцуулалт, ~~тай~~ нислэг үргэлжлэх хугацаа;
 - (v) тээвэрлэж байгаа хүний нийт тоо;
 - (vi) сонирхогчийн нислэгийн операторын нэр болон холбогдох дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (vii) **нислэгт авч яваа**, эрэн хайх, авран хамгаалах төвтэй яаралтай холбоо барих ~~нислэгт авч яваа~~ онцгой байдлын болон ~~өслын~~ **аврах** тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (2) сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааг дуусгахаар урьдчилан тохирсон цаг бөжсөн байна;
- (3) хэрэв нислэгийг холбоо үргэлж барих боломжгүй бүсэд хийхээр төлөвлөж байгаа бол агаарын хөлгийн даргатай эргэн холбоо тогтоох цаг бөжсөн байна;
- (4) агаарын хөлгийн дарга нислэгийн аюулгүй ажиллагаанд чухал шаардлагатай мэдээллийг ~~нислэг дагах үйлчилгээнд~~ нислэгийн **хяналтын хэсэгт** мэдэгдэх бусад арга хэрэгсэл;
- (5) хэрэв агаарын хөлгийн дарга энэ хэсгийн (2), (3), буюу (4)-ийн дагуу урьдчилан тохирсон цагт холбоо барьж чадаагүй бол дараах газруудад нэн даруй мэдэгдэнэ—
 - (i) үндэсний эрэн хайх, авран ~~хамгаалах~~ **туслах мэдээлэл** зохицуулах төв; эсхүл
 - (ii) **Даргын хүлээн зөвшөөрсөн**, онцгой байдлыг зарлах ~~арга хэмжээ авах чадвартай~~ **эрх бүхий** байгууллага.

115.73 Ашиглалтын журмыг Журам тогтоох

(a) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь энэ дүрэм болон холбогдох бусад дүрмэнд заасан холбогдох шаардлагыг даган мөрдөх журмыг тогтооно.

(b) Энэ зүйлийн (a) -т шаардсан журмууд нь—

- (1) явуулах **үйл** ажиллагааны төрөлд ~~хамаарна~~ **нийцсэн байх**;
- (2) тодорхой шаардлагыг даган мөрдөх арга хэрэгслийн **үзүүлэх** талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хангалттай оруулсан байна;
- (3) төлөвлөсөн ажиллагаатай холбоотой аюулгүй байдлын эрсдлийг удирдах талаар дэлгэрэнгүй мэдээллийг ~~хангалттай оруулсан байна~~ **тусгасан байх**;
- (4) Дарга хүлээн зөвшөөрөхүйц байна.

115.75 Осол зөрчлийг мэдээлэх

Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь ИНД-12-ын дагуу бүх зөрчлийг мэдэгдэх, мөрдөн шалгах, мэдээлэх ~~эд шаардлагатай~~ журмыг тогтооно.

115.77 Аюулгүй ажиллагааны удирдлага

Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь **ИНД-100-гийн** 100.3-ийн дагуу аюулгүй ажиллагааны удирдлагын системийг тогтоох, хэрэгжүүлэх, зүй зохистой түвшинд хадгалах үүрэг хүлээнэ.

115.79 Сонирхогчийн нислэгийн операторын үйл ажиллагааны заавар

(a) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь ~~Даргад дараах зүйлийг агуулсан үйл ажиллагааны үзүүлэнг дэлгэн үзүүлнэ зааврыг Даргад ирүүлнэ—~~

- (1) өргөдөл гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс ерөнхий захирал гарын үсэг зурсан батламж нь дараах зүйлийг батална—
 - (i) үйл ажиллагааны ~~үзүүлэн~~ **заавар** болон хавсаргасан бусад заавар нь сонирхогчийн нислэгийн байгууллагыг тодорхойлж, энэ дүрэм болон холбогдох бусад дүрмэнд заасан шаардлагыг даган мөрдөж байгаа арга хэрэгслийг үзүүлнэ;
 - (ii) үйл ажиллагааны ~~үзүүлэн~~ **заавар** болон хавсаргасан бусад зааврыг тухайн байгууллагын ажилтнууд цаг үргэлж даган мөрдөх шаардлагатай;

- (1A) 115.77-д шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын системийн хувьд—
- (i) 100.3 (b)-т шаардсан бүх баримт бичиг;
 - (ii) сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ сунгахаар биш шинээр өргөдөл гаргагчийн хувьд, аюулгүй ажиллагааны удирдлагын системийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх өрүүлсэн хэрэгжүүлэх төлөвлөгөө;
- (2) 115.51(a)(1) болон (2)-оор шаардсан удирдах хүмүүсийн албан тушаал болон нэрс;
- (3) 115.51(a)(1) болон (2)-оор шаардсан удирдах хүмүүсийн ажил үүрэг, хариуцлага, үүнд—
- (i) байгууллагын нэрийн өмнөөс Дарга буюу эрх бүхий байгууллагатай шууд харилцах үүрэгтэй асуудлууд;
 - (ii) аюулгүй ажиллагааны удирдлагын үүрэг хариуцлагууд;
- (4) зохих тохиолдолд, 115.51(a)(1) болон (2)-оор шаардсан удирдах албан тушаалтнуудын үүрэг хариуцлагын шугамыг энэ хэсгийн (5)-д заасан байрлал бүрээр дэлгэн үзүүлсэн зохион байгуулалтын бүдүүвч зураг;
- (5) үйл ажиллагааны үндсэн газар болон техник үйлчилгээний үндсэн баазын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (5A) байгууллагын хэмжээнд аюулгүй ажиллагааны үүрэг хариуцлагын шугамыг үзүүлсэн мэдээлэл
- (6) энэ дүрмээр шаардсан өргөдөл гаргагчийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (7) дараах зүйлийн дэлгэрэнгүй мэдээлэл—
- (i) 115.59 болон 115.61-д шаардсан техник үйлчилгээний журмууд;
 - (ii) 115.61-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөр;
 - (iii) өргөдөл гаргагчийн агаарын хөлөг дээр техник үйлчилгээ гүйцэтгэдэг техник үйлчилгээний байгууллага бүр;
- (8) дараах зүйлийн дэлгэрэнгүй мэдээлэл—
- (i) 115.62-д шаардсан мансууруулах бодис болон согтууруулах ундааны хөтөлбөр;
 - (ii) 115.62-д заасан аливаа этгээдийг эдгээр бодисын нөлөөлөлд автан хөдөлмөрийн чадваргүй болсон гэж өргөдөл гаргагч үзвэл 115.231-д шаардсан сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааг явуулахгүй байх арга хэрэгслүүд;
- (9) дараах зүйлийн дэлгэрэнгүй мэдээлэл—

- (i) энэ дүрмийн Ж Бүлгээр шаардсан нислэгийн болон **ажил** үүргийн цагийг бүртгэх зохицуулах схем;
 - (ii) сонирхогчийн нислэгийн төрөлд хамаарах аюулгүй ажиллагаа, онцгой байдлын журмыг зорчигчдод танилцуулах **брифинг** буюу сургалт;
 - (iii) 115.209-д шаардсан онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;
 - (iv) энэ дүрмийн Д Бүлгээр шаардсан нисгэх баг болон газрын багийн сургалтын хөтөлбөр;
 - (v) энэ дүрмийн Е Бүлгээр шаардсан нисгэх багийн гишүүн болон газрын багийн чадварыг үнэлэх хөтөлбөр;
- (10) энэ дүрмээр шаардлагатай гэж шаардсан хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (11) үйл ажиллагааны **үзүүлэнг зааврыг** хянах, өөрчлөх болон тараах журмууд.
- (b) Өргөдөл гаргагч нь өөрийн үйл ажиллагааны **үзүүлэнг зааврыг** Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт байнга байлгах үүрэг хүлээнэ.

В Бүлэг. Үйл ажиллагааны хязгаарлалт болон шаардлага

115.101 Байнгын хэрэгжилт

- (a) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь 115.13-д шаардсан үйл ажиллагааны тодорхойлолтын шаардлагыг даган мөрдөнө.
- (b) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь—
- (1) хамаарах стандартууд болон энэ дүрмийн Б Бүлгийн шаардлагыг байнга мөрдөнө;
 - (2) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны **үзүүлдэнд зааварт** байгаа бүх журам, хөтөлбөрийг даган мөрдөнө;
 - (3) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааварт заасан байрлал бүрт—
 - (i) гэрчилгээ эзэмшигчийн ажиллагааны тодорхойлолтын хүчин төгөлдөр нэг хувийг байлгана;
 - (ii) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны **үзүүлэнгийн зааврын** тухайн байрлалд холбоотой хэсгүүдийн хүчин төгөлдөр нэг хувийг цаасан, электрон буюу Даргын хүлээн зөвшөөрсөн бусад хэлбэрээр байлгана.

115.103 Нисгэх багийн мэргэшил

~~(а) Хэрэв аливаа этгээд хууль болон ИНД-61-ийн дагуу Даргын олгосон, эсхүл ИНД-149-ийн дагуу нисгэгчийн гэрчилгээ, зэрэглэл олгохоор гэрчилгээжсэн сонирхогчийн нислэгийн байгууллагын журмын дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх, гэрчилгээ болон зэрэглэл эзэмшихээс бусад тохиолдолд сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаанд тухайн этгээдэд нисгэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл олгохгүй бөгөөд тухайн этгээд нь нисгэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэж үл болно.~~

Хэрэв аливаа этгээд ИНД-61 –ийн дагуу Даргаас олгосон нисгэгчийн зохих үнэмлэх, зэрэглэлгүй, эсхүл ИНД-149 –ийн дагуу гэрчилгээжсэн байгууллагаас олгосон үнэмлэх үнэмлэх, зэрэглэлгүй бол Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь өөрийн үйл ажиллагаандаа тухайн этгээдийг агаарын хөлгийн багийн гишүүнээр нислэг үйлдэхийг зөвшөөрч болохгүй.

~~(б) Хэрэв аливаа этгээд хуулийн дагуу Даргын олгосон, эсхүл ИНД-149-ийн дагуу тандем шүхрийн мастерын гэрчилгээ гэрчилгээ олгохоор гэрчилгээжсэн сонирхогчийн нислэгийн байгууллагын журмын дагуу олгосон тандем шүхрийн мастерын гэрчилгээ эзэмшихээс бусад тохиолдолд сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаанд тухайн этгээдэд тандем шүхрийн мастерын үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл олгохгүй бөгөөд тухайн этгээд нь тандем шүхрийн мастерын үүрэг гүйцэтгэж үл болно.~~

Хэрэв аливаа этгээд ИНД-149 –ийн дагуу гэрчилгээжсэн байгууллагаас олгосон тандем мастерын гэрчилгээгүй бол Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь өөрийн үйл ажиллагаандаа тухайн этгээдийг тандем мастерын ажил үүргийг гүйцэтгүүлж болохгүй.

115.105 Бизнесийн буюу худалдааны нэр

(а) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээн дээр байгаа худалдааны буюу бизнесын нэрийг ашиглан сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааг явуулна.

(б) Сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаа явуулж байгаа гэрчилгээ эзэмшигчийн худалдааны буюу бизнесийн нэрийг агаарын хөлөгт суух буюу сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаанд оролцох гэж байгаа зорчигчид тодорхой танигдах, харагдах, уншигдахаар дэлгэн үзүүлэхээс бусад **байршуулаагүй** тохиолдолд аливаа этгээд сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэж үл болно **болохгүй**.

(с) Гэрчилгээ эзэмшигчийн сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой аливаа сурталчилгаанд гэрчилгээ эзэмшигчийн сонирхогчийн нислэгийн

операторын гэрчилгээн дээр байгаа бизнесийн буюу худалдааны нэрийг заавал тусгасан байна.

115.107 Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигчийн хязгаарлалт

Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээний эрхийн дор агаарын тээврийн ажиллагаа буюу арилжааны тээврийн ажиллагаа явуулж үл бөлнө болохгүй.

115.109 Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагад өөрчлөлт оруулах

(a) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь—

- (1) 115.79-д шаардсан үйл ажиллагааны үзүүлд ~~зааварт дараах байдлаар өөрчлөлт оруулна~~ **өөрчлөлт оруулахдаа дараах зүйлийг бататгана** —
 - (i) гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын хамгийн сүүлийн үеийн байдлыг төдөрхөйлсөн хэвээр байх **одоогийн үйл ажиллагааны чиглэл, тодорхойлолт хэвээр хадгалагдана гэдгийг;**
 - (ii) энэ дүрэм буюу бусад дүрмүүдэд заасан холбогдох шаардлагыг үргэлжлүүлэн даган мөрдсөн хэвээр байх **шаардлагууд хангагдана гэдгийг;**
- (2) үйл ажиллагааны үзүүлд ~~зааварт~~ оруулсан аливаа өөрчлөлтөөр энэ дүрэм болон бусад дүрмийн холбогдох шаардлагыг хангаж байгаа бөгөөд үйл ажиллагааны үзүүлд ~~зааварт~~ тусгасан өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдөнө **журмын дагуу хийгдсэн гэдгийг бататгана;**
- (3) өөрийн үйл ажиллагааны үзүүлд ~~зааварт~~ нэмэлт өөрчлөлт оруулсны дараа аль болох боломжит богино хугацаанд өөрчлөлт бүрийн хувийг Даргад илгээнэ.
- (4) ~~Дарга~~ нисэхийн аюулгүй ажиллагааны ашиг сонирхлын үүднээс зайлшгүй шаардлагатай гэж үзвэл **Даргаас шаардсан тохиолдолд**, өөрийн үйл ажиллагааны үзүүлд ~~зааварт~~ өөрчлөлт оруулна.

(b) Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд—өөрчлөлт **өөрчлөлтүүдийг** хийхийн өмнө Даргаас урьдчилан зөвшөөрөл авна:

- (1) ерөнхий захиралыг **солих;**
- (2) 115.79(a)(2)-д заасан аливаа удирдах хүний албан тушаал буюу нэрийг **солих, өөрчлөх;**

- (3) 115.79(a)(5)-д заасан гэрчилгээ эзэмшигч сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэх газрууд газрын байршил солигдох;
- (4) гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээний хамрах хүрээгээ өөрчлөх;
- (5) аюулгүй ажиллагааны удирдлагын системд оруулах ихээхэн (материаллаг) өөрчлөлт;
- (6) 115.61-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн өөрчлөлт;
- (7) гэрчилгээ эзэмшигчийн техник үйлчилгээг гүйцэтгэх гэрээт байгууллага солигдох;
- (8) 115.401-д шаардсан нислэг болон ажил үүргийн цагийн зохицуулалтын схемийн өөрчлөлт.

(c) Дарга нь энэ зүйлийн (b)-т заасан өөрчлөлт оруулах үед буюу эсхүл оруулсны дараа сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигчийн ажиллах нөхцлийг хязгаарлаж болно.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (c)-ийн дагуу Даргын хязгаарласан аливаа нөхцлийг даган мөрдөх үүрэгтэй.

(e) Хэрэв энэ зүйлийн (b)-т заасан аливаа өөрчлөлт нь гэрчилгээ буюу үйл ажиллагааны тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг шаардаж байвал, гэрчилгээ эзэмшигч нь орсон өөрчлөлтийг батлуулахын тулд гэрчилгээ буюу үйл ажиллагааны тодорхойлолтыг Даргад аль бөмөржийн хурдан хугацаанд нэн даруй илгээнэ.

115.111 Техник үйлчилгээний хөтөлбөрт өөрчлөлт оруулах

Хэрэв Дарга техник үйлчилгээний хөтөлбөрийн нислэгт тэнцэх чадварын шаардлагыг үргэлжлүүлэн хангахын тулд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч нь Даргын хүсэлтийн дагуу 115.61-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрт өөрчлөлт оруулна.

115.151 Сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигчид болон өргөдөл гаргагчийн шилжилт

(a) Энэ хэсэг нь дараах этгээдэд хамаарна—

- (1) сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ эзэмшигч бүрт;
- (2) сонирхогчийн нислэгийн операторын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч бүрт.

(b) 2021 оны 2 сарын 1-нээс өмнө энэ дүрэм хэсгийн баримтлах байгууллага нь—

- (1) дараах заалтыг дагаж мөрдөхийг шаардахгүй—

